

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 10

1. “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	4 - 10
--	--------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 51 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг;
Тасалсан: Х.Баттулга, Ж.Ганбаатар, О.Цогтгэрэл.

Нэг. “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан нар үг хэлэв.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан нарын гаргасан, нэр дэвших тухай хүсэлтийг нэг сарын хугацаатайгаар буюу 2024 оны 12 дугаар сарын 05-наас 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч, нэр дэвшигчээр бүртгэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
16 цаг 51 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Хуралдаанд ирсэн гишүүд Р.Сэддорж, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Л.Соронзонболд, А.Ундраа, Б.Найдалаа, П.Сайнзориг, С.Цэнгүүн гишүүд хүрэлцэн ирсэн.

О.Батнайрамдал гишүүн гадаад томилолттой, П.Батчимэг гишүүн өвчтэй, Ш.Бямбасүрэн гишүүн гадаад томилолттой, Г.Лувсанжамц гишүүн гадаад томилолттой байна.

Ингээд хуралдааны ирц 52 хувьтай байгаа учраас Байнгын хорооны хуралдаан ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Өөр саналтай гишүүд. Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Төслийг уншиж танилцуулъя.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.7 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 27³ дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг⁸ Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч нэр дэвшигчээр бүртгэхээр тогтоосугай.

2.Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Л.Соронзонболд гишүүнээр тасалъя. П.Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Баярлалаа. Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороонд гишүүнээр ороод анхны хуралдаа сууж байна. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор ганц санал байна.

Ер нь зүгээр яах вэ хууль зүйн салбарын нээлттэй сонгон шалгаруулалтын асуудлууд хууль болон Байнгын хорооноос тогтоосон журмын дагуу явж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл гээд.

Ер нь хүмүүсийн оролцоог хангах талаасаа энэ хугацааг жоохон тавиу тавьж өгөөч ээ. 14 хоног бол багадна. Тэгээд оны төгсгөл дээр болж байна. Хувь хүн талаасаа ажил амьдралын яг төлөвлөлтүүд явж байгаа.

Ер нь санхүүгийн салбарын хувьд яг оны эцэс, ирэх жилийн тооцоо, төлөвлөгөө гээд явж байдаг.

Тэгээд ер нь хувь хүн амьдралынхаа чухал асуудал дээр өөрсдөө дэвших үү, үгүй юу, сонгон шалгаруулалтад орох уу, үгүй юу гээд бодож байх энэ хугацаан дээрээ жоохон тавиу байж өгөх ёстой юм билээ. Ингэж байж салбар салбарын мэргэжилтэй хүмүүс илүү их орж өгнө.

Ийм богино хугацаанд хийгээд өнгөрвөл харин хардалтууд явагдана.

Тийм учраас би үүнийг нэг сарын хугацаатайгаар жоохон уужуу тавьж өгье.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр ийм нэр дэвшүүлэлтийн ажлууд явж байгаа гэдэг зараа сайн хүргэе. Ийм байдлаар явахад өнөөдөр нэг их яарч сандраад байгаа тулчихсан асуудал байхгүй байх гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр энэ жишгийг бодоод 12 сарын 05-ны өдрөөс 12 сарын 19-ний өдөр гэснийг 01 сарын 05-ны өдөр хүртэл. 01 сарын 04 үү, 05 уу? Үүнийг нь манай Байнгын хороо яачихна биз. 30 хоногоор ажил явуулчихмаар санагдаад байх юм.

Тэгээд ийм зүйлүүдийг анхаараад явчихъя. Тэгээд ийм л саналтай байна. Бусдаар хэлэх зүйл байхгүй байна.

Р.Сэддорж: Санал байна. Тийм ээ. Тийм байна.

Л.Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Бүгдэд нь оройн мэнд.

Ерөнхийдөө П.Сайнзориг гишүүнтэй ойролцоо агуулгатай. Юу гэхээр ер нь аль ч хүн хөдөлмөрийн хуулиараа, байгууллагаас хөдөлмөрийн гэрээгээ цуцлахдаа нэг сарын өмнө мэдэгдэх ёстой шүү дээ. Тийм ээ.

Тэр утгаар нь бодоод үзэхээр одоо бид нарын өнөөдрийн энэ зарлаж байгаа энэ ажлууд маань нэлээн хариуцлагатай ажлууд байгаа учраас өнөөдөр тодорхой ажил эрхэлж байгаа улсуудын хувьд байгууллагадаа эхлээд мэдэгдэнэ.

Тэгэхэд доор хаяж нэг сарын өмнө мэдэгдэх ёстой. Энэ процессуудыг нь бодоод үзэхээр сонгон шалгаруулалтын процесст оролцох хүсэлтэй мөртлөө хөдөлмөрийн хуулийн зохион байгуулалтаас болоод, зохицуулалтаас болоод оролцохгүй байх асуудал үүсэж болзошгүй учраас энэ хугацааг нь саяын

П.Сайнзориг гишүүнтэй адил саналаар буюу энэ хангалттай хугацаа тавьж өгөх ёстой байх л гэсэн нэг ийм саналтай байна.

Тэгэхээр П.Сайнзориг гишүүний санал дээр санал хураалгахад нэг их татгалзах зүйлгүй байна гэж бодож байна.

Р.Сэддорж: Өөр саналтай гишүүд байна уу?

Гишүүд асуулт асууж, санал хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хугацаан дээр өөрчлөлт орох гэж байна. Тийм ээ. П.Сайнзориг гишүүн нэмж тайлбарлах юу байна уу?

Одоо энэ санал хураалттай холбоотой үг хэлж болно шүү дээ. Тийм. Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: П.Сайнзориг мэдэж байна уу, үгүй юу? Хууль зүйн байнгын хороон дээр бид тэр нөгөө юуны хүнийг сонгосон юм. Тийм. Тэгсэн чинь тэр байна шүү дээ. 14 хоногт 2-хон хүн саналаа өгсөн байна лээ.

Тэгээд сүүлдээ мэдэхгүй, мэдсэн, мэдээгүй гэсэн асуудлууд яригдсан учраас Р.Сэддорж дарга аа, энэ хамгийн багадаа сар байх ёстой.

Дээр нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах ёстой л юм билээ. Ганцхан парламент гэсэн сайт дээр тавьчихсан. Тэр нь орж үздэг хүн байдаггүй.

Тэгээд хэдхэн хүн орж үздэг. Зохион байгуулалттай ганц нэг хүн орж үздэг. Чи тийшээ ороорой. Тэнд тавьчихсан шүү гээд хэлчихсэн. Тэгээд 2-хон хүн орж ирсэн байгаа байхгүй юу.

Хэрвээ үнэхээр Монголбанкны хяналтын хорооны дарга энэ чухал чухал ажлуудыг мэргэжлийн өндөр түвшний хүмүүсийг оруулж ирье гэх юм бол нээлттэй зарлаж өшөө илүү сурталчлах ёстой л юм байна лээ.

Тийм учраас миний санал бол энэ хугацаагаа та хэд маань ингээд сунгаж өгөөч ээ.

Хоёрт нь, зарыг олон нийтэд мэдээлэх хэрэгслийг нэлээн тийм хүчтэй хиймээр юм билээ.

Ер нь цаашдаа бид энэ Монголбанкны Ерөнхийлөгчийг ч гэсэн ингэж олон нийтээс санал авч байж сонгодог тийм жишиг рүү орох ёстой юм байна гэж би бодож байгаа.

Тэгэхгүй бол нэг дарга сонгодог одоо тийм системтэй явж байгаа шүү дээ. Ганцхан дарга эндээс томилж өгөөд явуулчихдаг. Тэр хүн нь орж ирээд л

батлагдаад явчихдаг. Нийтдээ ер нь ингэж ийм олон нийтийн хэлэлцүүлгээр сонгогддог байх юм бол жинхэнэ ардчилсан зарчим байх юм гэж би бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Одоо бол шинэ жилийн уур амьсгал, байгууллагуудын санхүүгийн жил хаагдаж байгаа. Тийм ээ. Тэгээд санхүүгийн нягтлангууд, санхүүгийн салбарынхан бол жилийн оны эцсийн ажил гээд нэлээн ажилтай ийм үе таарч байгаа.

Ийм учраас гишүүдийн гаргасан саналаар санал хураалт явуулаад шийдчихье. Тийм ээ.

Өөр саналтай гишүүд байна уу? Нэг сар болгоё гэсэн саналтай байна. Өөр саналтай гишүүд байна уу? Өөр саналтай гишүүд байхгүй байна.

Ингээд нэр дэвших хүсэлтийг нэг сарын хугацаатайгаар 12 дугаар сарын 05-наас 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр гэсэн. Ингэж байж нэг сар болж байгаа гэж байгаа юм байна.

Одоо энэ чинь бүгд онлайнаар бүртгүүлнэ. Тийм ээ. Маягтыг баталсан байгаа.

Ингээд би бол одоо ийм саналтай байгаа. Их Хурлын дарга хэлсэн учраас. Тийм ээ. Төрийн ажил нэгдсэн байдлаар бусад бүх Байнгын хороо 14 хоног гэж байгаа шүү гэж хэлж байгаа юм.

Тэгэхээр би бол 14 хоног дээрээ гараа өргөнө гэсэн үг. Ийм нэг квоттой шүү дээ. Ер нь. Тийм ээ. Хууль зүйн байнгын хорооноос Монголбанк руу нэг хүн, Санхүүгийн зохицуулах хороо руу гээд л иймэрхүү юмнууд байгаа.

Ийм учраас яг манайх шиг ингээд хэлэлцэж байгаа байх. Ингээд санал хураалт. Манайх бол хамгийн олонхыг нь дэвшүүлнэ ээ л гэсэн үг.

Тийм. Ингээд олонх гишүүдийн. Хоёр, гурван гишүүн санал гаргасан.

Ингээд 2024 оны 12 сарын 05-наас 2025 оны 01 сарын 06-ны өдөр гэсэн.

Энэ дээр саналтай гишүүд санал хураалт. Одоо шууд санал хураалт. /алх цохив/

58.8 хувийн саналаар 3 гишүүнээс гаргасан санал дэмжигдлээ.

Протокол дээр Д.Энхтүвшин гишүүн, М.Бадамсүрэн гишүүн, М.Мандхай гишүүдийг дэмжсэнээр оруулахыг хүсэж байна. Протокол тэмдэглээрэй.

Байнгын хорооны тогтоол.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулын 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.7 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч нэр дэвшигчээр бүртгэхээр тогтоосугай.

2. Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Эдийн засгийн байнгын хорооны дарга гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

82.4 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Дэгийн тухай хуулиар гишүүд нэр дэвшигч санал болгох эрхтэй. Ийм учраас та бүхэн нэр дэвшигчдийг бүртгэж дууссаны дараа тэдгээрт сонгон шалгаруулалт явуулж нэр дэвшүүлнэ.

Гишүүд нэр дэвшүүлж буй хүнийхээ танилцуулга, анкетыг Байнгын хорооны өрөө буюу 305 тоотод хүргүүлээрэй гэдгийг хэлье.

Энэ бол Улсын Их Хуралд ажлаас шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам дээр байгаа.

Байнгын хорооны хуульд заасны дагуу албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ гишүүдээс санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт

явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.

Дэгийн хууль дээр ийм заалт байгаа юм байна. Тэгээд Та бүхэн дэвшүүлэх хүмүүсийнхээ нэрийг өгөх нь байна.

Санал хураалт явуулж дууслаа.

Нэр дэвшигчийг бүртгэх тухай Байнгын хорооны тогтоолын эцсийн хэлэлцүүлэг дууслаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаан идэвхтэй оролцсон гишүүдээ баярлалаа. М.Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Бусад бүх гишүүдэд баярлалаа.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 17 цаг 10 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД